# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
# ТУШААЛ

2021 оны 09 сарын 16 өдөр Дугаар А/219 Мандалговь

"БОНӨБЭрдэнэ холбоо" НҮТББ-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 33 дугаар зүйл 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хийгдэх "Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөр" зөвлөх үйлчилгээний ажилд ирүүлсэн үнийн саналаар "БОНӨБЭрдэнэ холбоо" НҮТББ -тай 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан хөтөлбөрийн дагуу Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөр ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "БОНӨБЭрдэнэ холбоо" НҮТББ -ны захирал (Б.Өлзийсайхан)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

4862111-3